



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 475,906,749.22 (дөрвөн зуун далан таван сая есөн зуун зургаан мянга долоон зуун дөчин есөн төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 395,002,976.60 (гурван зуун ерэн таван сая хоёр мянга есөн зуун далан зургаан төгрөг жаран мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 4 ширхэг автомашиныг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Улсын драмын эрдмийн театрын захирал Д.Цэрэнсамбуу, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Түмэндэмбэрэл, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Х.Улам-Өрнөх, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины татвар, төлбөр тооцоог барагдуулах арга хэмжээг 2020 оны 5 дугаар сард багтаан зохион байгуулах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ



0000043

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн
99 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРААС БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Тобото камри, 06-25 УНУ, 4Т4ВF1FK90R203117	2016/2016	ш	1.00	47,500,000.00	28,386,904.63	19,113,095.37	Улсын Драммын эрдмийн театр
2	Ланд круйзер 200, 08-18 УБИ, JTMHX05124044719	2013/2013	ш	1.00	165,176,000.00	116,081,988.98	49,094,011.02	Мал эмнэлэгийн ерөнхий газар
3	Соната-7, 04-03 УНУ	2013	ш	1.00	38,799,999.40	26,103,333.17	12,696,666.23	Төрийн худалдан авах ажиллагааны газар
4	Лексус LX 570, 00-99 ОРО	2019	ш	1.00	224,430,749.82	224,430,749.82	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
Нийт дүн					475,906,749.22	395,002,976.60	80,903,772.62	-
					(дөрвөн зуун далан таван сая есөн зуун зургаан мянга долоон зуун дөчин есөн төгрөг хорин хоёр мөнгө)	(гурван зуун ерэн таван сая хоёр мянга есөн зуун далан зургаан төгрөг жаран мөнгө)	(наян сая есөн зуун гурван мянга долоон зуун далан хоёр төгрөг жаран хоёр мөнгө)	